



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/134/НА-СТА-ТШЗ

| | |
|--|---|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025 оны 02 дугаар сар 17</p> | <p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер М.Алтантуяа Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК Захирал Г.Саранчимэг Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com Аудитор: О.Мандах Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com</p> |
|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|---|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 7 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 14 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 18 |
| 4.1 Ерөнхий зүйл | 18 |
| 4.2 Материаллаг байдал | 19 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 19 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал. | 19 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 19 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 20 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар | 20 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 21 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 21 |
| 5.1 Төлбөрийн акт | 21 |
| 5.2 Албан шаардлага..... | 21 |
| 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл..... | 22 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БШУС | Боловсрол, шинжлэх ухааны сайд |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101

Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/50

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2024 онд 6,396,143.2 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 6,180,268.5 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 4,146.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст харилцах дансанд 207,990.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

2024 оны байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр улсын хэмжээнд 3-р түвшинд үнэлэгдэн 82,217.5 мянган төгрөгийн гүйцэтгэлийн урамшуулал авч, багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд 102 багш шалгагдан 72 багш 1-4 дүгээр түвшинд үнэлэгдэн 15-40 хувийн үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр авсан байна.

Аудитын гол асуудал

5020264

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 үндсэн зорилт, 6 дэд зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 95.4 хувьтай тайлагнасныг 96.7 хувьтай дээд шатны байгууллагаас дүгнэсэн байна.

2023-2024 оны хичээлийн жилд Улсын хэмжээнд бага ангид 3-4-р ангид математикийн сургалтыг дэмжих EDUTEN хөтөлбөр, 5-6-р ангид Англи хэлний PEARSON хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|------------------------------------|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 825,343,095.28 | 718,036,688.46 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 359,421,422.43 | 207,990,950.32 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 359,421,422.43 | 207,990,950.32 |
| 3121 | Төгрөг | 359,421,422.43 | 207,990,950.32 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 359,421,422.43 | 207,990,950.32 |
| 33 | АВЛАГА | 1,500,010.71 | 00.00 |
| 335 | Бусад авлага | 1,500,010.71 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,500,010.71 | 00.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 464,421,662.14 | 510,045,738.14 |
| 351 | Түүхий эд материал | 262,174,061.58 | 294,690,639.58 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 250,184,061.58 | 286,536,904.58 |
| 35130 | Эм боох материал | 11,990,000.00 | 8,153,735.00 |
| 354 | Хангамжийн материал | 202,247,600.56 | 215,355,098.56 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 9,768,020.00 | 13,853,320.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 15,861,716.00 | 15,284,516.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 3,002,400.00 | 3,002,400.00 |
| 35460 | Хүнсний материал | 6,299,700.00 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 167,315,764.56 | 183,214,862.56 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,793,089,012.64 | 8,395,888,805.36 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,793,089,012.64 | 8,395,888,805.36 |
| 391 | Газар | 00.00 | 00.00 |
| 392 | Биет хөрөнгө | 1,980,102,554.06 | 7,579,223,180.20 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,732,180,283.90 | 7,220,097,651.90 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -401,973,711.65 | -493,576,484.62 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж | 921,269,069.48 | 1,009,547,961.74 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -513,778,895.64 | -448,947,942.69 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 338,164,544.32 | 411,123,919.87 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -160,186,606.35 | -183,449,796.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 32,413,358.00 | 32,413,358.00 |
| 39217 | Ном | 32,014,512.00 | 32,014,512.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 812,986,458.58 | 816,665,625.16 |
| 39301 | Програм хангамж | 8,767,798.00 | 13,067,798.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -8,356,339.42 | -8,977,172.84 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 812,575,000.00 | 812,575,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 3,618,432,107.92 | 9,113,925,493.82 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 00.00 | 65,750,901.98 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 00.00 | 65,750,901.98 |
| 413 | Өглөг | 00.00 | 65,750,901.98 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 2,003,153.98 |



Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|------------|---|--------------------------|-------------------------|
| 4136 | Бусад өглөг | 00.00 | 63,747,748.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 63,747,748.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 3,618,432,107.92 | 9,048,174,591.84 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,618,432,107.92 | 9,048,174,591.84 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,498,705,779.83 | 2,498,705,779.83 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,498,705,779.83 | 2,498,705,779.83 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -2,035,693,975.24 | 3,394,048,508.68 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -2,326,582,515.40 | -2,326,582,515.40 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 290,888,540.16 | 5,720,631,024.08 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 3,155,420,303.33 | 3,155,420,303.33 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 3,618,432,107.92 | 9,113,925,493.82 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-------------------------|--------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 5,005,362,733.50 | 11,745,177,968.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 105,937,831.50 | 5,758,135,168.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 105,937,831.50 | 5,758,135,168.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 21,196,180.00 | 45,941,200.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,404,000.00 | 27,814,700.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,792,180.00 | 18,126,500.00 |
| 120011 | Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө | 66,617,551.50 | 6,975,000.00 |
| 120012 | Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал | 18,124,100.00 | 5,705,218,968.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,899,424,902.00 | 5,987,042,800.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 4,248,614,800.00 | 5,334,471,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,248,614,800.00 | 5,334,471,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 14,351,002.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 14,351,002.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 636,459,100.00 | 652,571,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 636,459,100.00 | 652,571,300.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 4,714,474,193.34 | 6,315,435,484.08 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,714,474,193.34 | 6,315,435,484.08 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,668,780,158.78 | 6,249,741,795.50 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 3,023,325,228.13 | 4,213,251,192.50 |

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 210101 | Үндсэн цалин | 2,010,988,530.20 | 2,691,643,224.64 |
| 210102 | Нэмэгдэл | 885,820,635.80 | 1,286,210,549.86 |
| 210104 | Урамшуулал | 126,516,062.13 | 235,397,418.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 387,468,142.49 | 528,853,245.94 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 261,250,957.16 | 362,325,746.21 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 31,696,401.22 | 42,489,699.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 25,357,300.96 | 21,648,601.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,287,689.36 | 20,477,839.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 62,875,793.79 | 81,911,358.58 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 585,891,660.44 | 628,425,311.42 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 29,256,413.44 | 35,824,350.42 |
| 210302 | Түлш, халаалт | 498,238,883.00 | 534,246,994.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 58,396,364.00 | 58,353,967.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 64,958,019.00 | 112,806,182.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 32,585,460.00 | 21,369,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 1,739,698.62 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 479,315.38 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 600,000.00 | 1,500,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 18,084,342.00 | 58,458,588.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 13,688,217.00 | 29,259,030.00 |
| 2105 | Нормативт зардал | 266,351,900.00 | 262,272,188.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,123,100.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 264,228,800.00 | 262,272,188.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 36,457,705.00 | 5,034,270.00 |
| 210604 | Урсгал засвар | 36,457,705.00 | 5,034,270.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,144,320.00 | 2,084,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,144,320.00 | 2,084,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 18,057,503.50 | 41,449,768.98 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 881,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 17,176,503.50 | 41,449,768.98 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 285,125,680.22 | 455,565,636.66 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 48,890,619.00 | 153,558,111.38 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 151,000.00 | 8,672,850.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 236,084,061.22 | 293,334,675.28 |

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|-----------------------|-------------------------|
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 45,694,034.56 | 65,693,688.58 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 00.00 | 200,000.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 00.00 | 200,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 35,126,500.00 | 61,347,700.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 00.00 | 6,549,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 35,126,500.00 | 54,798,000.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 10,567,534.56 | 4,145,988.58 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,567,534.56 | 4,145,988.58 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 290,888,540.16 | 5,429,742,483.92 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 290,888,540.16 | 5,429,742,483.92 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 4,921,640,082.00 | 6,032,984,000.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 36,566,182.00 | 45,941,200.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 36,566,182.00 | 45,941,200.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 36,566,182.00 | 45,941,200.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 29,755,002.00 | 27,814,700.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,811,180.00 | 18,126,500.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,885,073,900.00 | 5,987,042,800.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 4,248,614,800.00 | 5,334,471,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,248,614,800.00 | 5,334,471,500.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 636,459,100.00 | 652,571,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 636,459,100.00 | 652,571,300.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 4,529,807,078.57 | 6,057,246,720.11 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,529,807,078.57 | 6,057,246,720.11 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,213,715,344.01 | 5,737,390,543.53 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 3,023,325,228.13 | 4,209,475,673.75 |
| 210101 | Үндсэн цалин | 2,010,988,530.20 | 2,633,362,334.98 |
| 210102 | Нэмэгдэл | 885,820,635.80 | 1,340,787,217.06 |
| 210104 | Урамшуулал | 126,516,062.13 | 235,326,121.71 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 395,636,345.94 | 527,680,700.00 |

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|-------------------------------|-------------------------------|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 269,419,160.61 | 358,822,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 31,696,401.22 | 42,214,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 25,357,300.96 | 21,107,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,287,689.36 | 21,107,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 62,875,793.79 | 84,428,900.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 585,891,660.44 | 628,425,311.42 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 29,256,413.44 | 35,751,471.42 |
| 210302 | Түлш, халаалт | 498,238,883.00 | 540,000,713.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 58,396,364.00 | 52,673,127.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 39,999,905.00 | 20,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 39,999,905.00 | 20,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 28,722,940.01 | 120,583,242.36 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,200,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 26,522,940.01 | 120,583,242.36 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 140,139,264.49 | 231,225,616.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 97,496,164.49 | 181,182,616.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 42,643,100.00 | 50,043,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 316,091,734.56 | 319,856,176.58 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 305,524,200.00 | 315,710,188.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 270,534,200.00 | 262,272,188.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 34,990,000.00 | 53,438,000.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 10,567,534.56 | 4,145,988.58 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,567,534.56 | 4,145,988.58 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>391,833,003.43</u> | <u>-24,262,720.11</u> |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | <u>00.00</u> | <u>00.00</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 130,743,500.00 | 127,167,752.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 130,743,500.00 | 127,167,752.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 130,743,500.00 | 127,167,752.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 130,743,500.00 | 127,167,752.00 |
| 2260 | Гадаад эх үүсвэрээр | 00.00 | 00.00 |
| 226001 | Гадаад эх үүсвэрээр | 00.00 | 00.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>-130,743,500.00</u> | <u>-127,167,752.00</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 261,089,503.43 | -151,430,472.11 |

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|----|---|----------------|----------------|
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 98,331,919.00 | 359,421,422.43 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 359,421,422.43 | 207,990,950.32 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| C01 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,498,705,779.83 | 3,155,420,303.33 | 2,035,693,975.24 | 3,618,432,107.92 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| C08 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,498,705,779.83 | 3,155,420,303.33 | 2,035,693,975.24 | 3,618,432,107.92 |
| D01 | 2024 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,498,705,779.83 | 3,155,420,303.33 | 2,035,693,975.24 | 3,618,432,107.92 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,498,705,779.83 | 3,155,420,303.33 | 2,035,693,975.24 | 3,618,432,107.92 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 5,429,742,483.92 | 5,429,742,483.92 |
| D09 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,498,705,779.83 | 3,155,420,303.33 | 3,394,048,508.68 | 9,048,174,591.84 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | хувь |
|-----------------------|--|---------------|------------------|----------------|-------|
| | | төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 5,743,571,900 | 5,531,843,172.11 | 211,728,727.89 | 96.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,743,571,900 | 5,531,843,172.11 | 211,728,727.89 | 96.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 5,403,524,000 | 5,216,132,984.11 | 187,391,015.89 | 96.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 4,372,944,800 | 4,209,475,673.75 | 163,469,126.25 | 96.3 |
| 210101 | Үндсэн цалин | 3,000,217,200 | 2,633,362,334.98 | 366,854,865.02 | 87.8 |
| 210102 | Нэмэгдэл | 1,198,392,800 | 1,340,787,217.06 | 142,394,417.06 | 111.9 |
| 210104 | Урамшуулал | 174,334,800 | 235,326,121.71 | -60,991,321.71 | 135.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 546,618,000 | 527,680,700.00 | 18,937,300.00 | 96.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 351,053,500 | 358,822,900.00 | -7,769,400.00 | 102.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 64,376,200 | 42,214,500.00 | 22,161,700.00 | 65.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 21,864,700 | 21,107,200.00 | 757,500.00 | 96.5 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 21,864,700 | 21,107,200.00 | 757,500.00 | 96.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 87,458,900 | 84,428,900.00 | 3,030,000.00 | 96.5 |

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | | | |
|---------------|---|---------------|------------------|----------------|-------|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 647,571,300 | 628,425,311.42 | 19,145,988.58 | 97.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 33,000,000 | 35,751,471.42 | -2,751,471.42 | 108.3 |
| 210302 | Түлш, халаалт | 556,071,300 | 540,000,713.00 | 16,070,587.00 | 97.1 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 58,500,000 | 52,673,127.00 | 5,826,873.00 | 90.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 20,000,000 | 20,000,000.00 | 00.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 20,000,000 | 20,000,000.00 | 00.00 | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 120,916,800 | 120,583,242.36 | 333,557.64 | 99.7 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 120,916,800 | 120,583,242.36 | 333,557.64 | 99.7 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 363,044,400 | 358393368.00 | 4,651,032.00 | 98.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 313,001,400 | 308,350,368.00 | 4,651,032.00 | 98.5 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 50,043,000 | 50,043,000.00 | 00.00 | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 340,047,900 | 315710188.00 | 24,337,712.00 | 92.8 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 340,047,900 | 315,710,188.00 | 24,337,712.00 | 92.8 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 286,606,500 | 262,272,188.00 | 24,334,312.00 | 91.5 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 53,441,400 | 53,438,000.00 | 3,400.00 | 100.0 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 5,743,571,900 | 5,380,412,700.00 | 363,159,200.00 | 93.7 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 5,334,471,500 | 5,334,471,500.00 | 00.00 | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 5,334,471,500 | 5,334,471,500.00 | 00.00 | 100.0 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 409,100,400 | 404,969,100.00 | 4,131,300.00 | 99.0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 40,062,500 | 27,814,700.00 | 12,247,800.00 | 69.4 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,010,000 | 18,126,500.00 | -8,116,500.00 | 181.1 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 359,027,900 | 359,027,900.00 | 00.00 | 100.0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00 | 359,421,422.43 | 359,421,422.43 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00 | 207,990,950.32 | 207,990,950.32 | |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 01 | 01 | | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01 | 01 | | 100.0 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | | | |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 166 | 161 | 5 | 96.9 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | | 100 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 131 | 135 | -4 | 103 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 34 | 25 | -9 | 73.5 |
| 620004 | Гэрээт ажилтан | | | | |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | | | | |
| 630 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД | 2521 | 2521 | | 100 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 2521 | 2,521 | | 100 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор сумын Номгон ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд тодорхойлсон “Суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

2023-2024 оны хичээлийн жилд

- Бие дааж бүтээлчээр суралцана.
- Бусдыгаа хүндэлж хамтарч хөгжинө.
- Байнга цэвэрч, цэгцтэй байна.
- Баяр хөөртэйгээр сургуульдаа ирнэ гэсэн зорилго тавин

Дараах зорилтуудыг тавин ажилласан байна. Үүнд:

1. Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилсан боловсролын үйлчилгээг эрхэмлэн, олон нийтийн санал санаачилгыг ханган үр дүнтэй, ажиллах
2. Хүүхэд нэг бүрийн сурч боловсрох бүхий л үйлийг дэмжин, сурлагын чанарт ахиц гаргах
3. Багш нарын мэргэжлийн хөгжлийг тасралтгүй дэмжин, багшийн ёс зүй, харилцаа, заах арга, ур чадварт ахиц гаргах
4. Суралцагчдад шинжлэн судлах арга барил эзэмшүүлэн, хүүхэд нэг бүрийн оролцоог бодитойгоор нэмэгдүүлэх
5. Суралцагчдад сургалтын технологийн дэвшил ашиглан суралцах тэгш боломжийг бүрдүүлэн, ажил мэргэжлийн чиг баримжааг насны онцлогт тохируулан олгох
6. Сургуулийн номын санг сурах, сургах үйл ажиллагааны нээлттэй орчин болгож, хүүхдийн сурч, хөгжих, төлөвшихөд хамтран ажиллах
7. Сурагчдад орон зай, цаг хугацаанаас үл хамааран сурах боломжийг дэмжсэн ажлыг чанартай, хүртээмжтэй зохион байгуулж, эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх
8. Насан туршдаа суралцахуйн иргэд, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг бүхий л түвшинд чанартай зохион байгуулж ажиллах

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургууль нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захирлын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дугаар тушаалаар Захиргаа аж ахуй, Сургалтын алба бүтэц зохион байгуулалттай 161 орон тоотой, 2521 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс

урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн “Журам батлах тухай “ 25 дугаар тогтоолын хавсралт” Боловсролын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”
- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр журам батлах тухай” 39 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2024 оны 2 дугаар сарын 28-ний өдрийн “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 84, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд Боловсролын ерөнхий газар болон аймгийн Боловсролын газраас хяналт, шинжилгээ, дотоод аудитын шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-1 ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,495,493.4 мянган төгрөгөөр буюу 51.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|--------------------|--------------------|-------------|
| А | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 359,421.4 | 207,991.0 | (151,430.4) |
| Авлага | 1,500.0 | | (1,500.0) |
| Бараа материал | 464,421.7 | 510,045.7 | 45,624.0 |
| Үндсэн хөрөнгө | 3,877,384.5 | 9,530,840.2 | 5,653,455.7 |
| Хуримтлагдсан элэгдэл | (1,084,295.5) | (1,134,951.4) | (50,655.9) |
| Нийт хөрөнгө | 3,618,432.1 | 9,113,925.5 | 5,495,493.4 |
| Өр төлбөр | | 65,750.9 | 65,750.9 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 3,618,432.1 | 9,048,174.6 | 5,429,742.5 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 3,618,432.1 | 9,113,925.5 | 5,495,493.4 |

Эх сурвалж: Баянхонгор сумын Номгон сургуулийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2024 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь өглөг, үндсэн хөрөнгийн данс байна.

Мөнгөн хөрөнгө оны эхэнд 359,421.4 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй оны эцэст 207,991.0 мянган төгрөгийн өмнөх оноос 151,430.4 мянган төгрөгөөр буурсан нь оны эхний үлдэгдлээс зарцуулсан байна.

Тайланд онд 2023 оны авлага 1500:0 мянган төгрөгийг барагдуулж, авлагын үлдэгдэлгүй байна.

Бараа материал тайланд онд төсвийн хөрөнгөөр 425,355.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 6,975.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлого авч үйл ажиллагаанд 357,447.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, Захирлын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн “Эргэлтийн хөрөнгө актлах тухай” А/63 дугаар тушаалаар 29,259.0 мянган төгрөгийн бараа материал акталж, бараа материалын үлдэгдэл 45,624.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө худалдаж авч нийт 5,653,455.7 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Үндсэн хөрөнгөнд эзэмшигч тогтоох тухай” 25 дугаар тогтоолоор 20,000.0 их засвар, 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн “Балансаас балансад шилжүүлэх тухай” 81 дүгээр захирамжаар 750.0 мянган төгрөгийн телевизор, 2024 оны 11 дүгээр сарын 18-ны

“Үндсэн хөрөнгөнд эзэмшигч тогтоох тухай” 99 дүгээр захирамжаар сургуулийн барилгын өргөтгөлийн барилга 5,467,917.4 мянган төгрөгийн хөрөнгүүдийг үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлогоор авч Баянхонгор аймгийн ИТХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Хөрөнгө акталж, данснаас хасах тухай 2/13 дугаар тогтоолоор 242,678.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж үндсэн хөрөнгөөс хасалт хийсэн байна.

Нийгмийн даатгалын шимтгэлд 1,347.9 мянга, ХХАОТатвар 655.2 мянга, байгууллагад төлөх өглөг 63,747.7 мянган төгрөг нийт өглөг 65,750.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь дижитал кабинет байгуулж төлбөрийг хэсэгчлэн төлж байгаатай холбоотой өглөг 96.9 хувийг эзэлж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 5,429,742.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, 9,048,174.6 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 5,429,742.5 мянган төгрөгөөр нэмэгдэж 9,048,174.6 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,396,143.2 мянган төгрөгөөр төлөвлөж, зарлагыг 6,396,143.2 мянган төгрөгөөр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналаас 1380,895.9 мянган төгрөгөөр буурч 5,015,247.3 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 6,396,143.2 мянган төгрөг болгож 1380,895.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь багш ажилчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 5,334,471.5 мянган төгрөгийн санхүүжилтийг авч өмнөх оны харилцах дансны үлдэгдлээс 359,027.9 мянга, үйл ажиллагааны орлогоос 50,072.5 мянга, орон нутгийн төсвөөс 652,571.3 мянган төгрөг нийт 6,396,143.2 мянган төгрөгийн эх үүсвэртэй гүйцэтгэлээр 6,180,268.5 мянган төгрөгийг зарцуулж, 207,748.1 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 652,571.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 99.4 хувь буюу 648,635.3 мянган төгрөгийг зарцуулж, 4,146.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| № | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-----|--|--------------|--------------|------------|---------|
| 1 | 80226 Байр ашиглалтын үйлчилгээ | 12,332.70 | 12,332.70 | 0.0 | 100.0% |
| 3 | 80312 Сургалт семинар | 8,243.60 | 8,243.60 | 0.0 | 100.0% |
| 4 | 81605 Эрүүл мэндийг дэмжих | 18,252.90 | 18,180.00 | 72.9 | 99.6% |
| 5 | 81801 Үдийн цай хөтөлбөр | 286,606.50 | 262,272.20 | 24,334.3 | 91.5% |
| 6 | 81844 гүнгийрүүлсэн сургалт | 50,072.50 | 45,531.40 | 4,541.1 | 90.9% |
| 7 | 81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 101,215.90 | 101,215.90 | 0.0 | 100.0% |
| 8 | 81823 Боловсролын байгууллагын багш | 37,001.50 | 36,845.40 | 156.1 | 99.6% |
| 9 | 81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр | 54,165.80 | 54,165.80 | 0.0 | 100.0% |
| 10 | 81834 Боловсролын стандарт, сургалтын | 4,859,274.70 | 4,680,013.30 | 179,261.4 | 96.3% |
| 11 | 81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 273,316.90 | 270,288.60 | 3,028.3 | 98.9% |
| 12 | 81875 Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх | 30,924.30 | 30,590.70 | 333.6 | 98.9% |
| 13 | 80233 Хүүхэд хамгаалал | 12,164.60 | 12,163.60 | 1.0 | 100.0% |
| 14 | 80112 Нийтлэг үйлчилгээ | 652,571.30 | 652,571.30 | | 100.0% |
| ДҮН | | 6,396,143.20 | 6,184,414.50 | 211,728.70 | 96.7% |

Эх сурвалж:2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон Аудит ХХК-ийн захирал, аудитор Г.Саранчимэг багийг ахалж аудитор О.Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2025 оны 1 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлсэн байна.



Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Л.Сарангэрэл, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Т.Цэрэндолгор нар зурж, нярваар Л.Оюунцэцэг, Б. Цолмон нар ажиллажээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийн зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг оны батлагдсан төсөв 5,743,571.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 57,435.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 43,076.8 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 5,968,190.4 мянган төгрөгийн 119 гүйлгээ, зарлагын 1,120,270.6 мянган төгрөгийн 95 гүйлгээ, хуулийн хугацаанд мэдээлсэн байна. 2 мэдээг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Худалдан авах ажиллагааны талаар

Тус сургууль нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил үйлчилгээ худалдан авах үнэлгээний хороог захирлын 2024 оны 01 дүгээр сарын 15 ны өдрийн А/05 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, үдийн хоолны 273,682.6 мянган төгрөгийн материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах

тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулахаар 2024 оны 1 дугаар сарын 23-ны өдрөөс 02 дугаар сарын 23-ний өдрийг хүртэл ажлын 30 хоногт багтан худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д тендерийн бичиг баримтыг байршуулсан байна.

Ерөнхий боловсролын сургуульд цахим системд суурилсан англи хэлний хөтөлбөр нэвтрүүлэх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс 04 дүгээр сарын 29-ны өдөр хүртэлх ажлын 5 хоногт багтаан харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д тендерийн бичиг баримтыг байршуулсан байна.

Үдийн хоолны материал нийлүүлэх тендерийг 4 багц, Ерөнхий боловсролын сургуульд цахим системд суурилсан англи хэлний хөтөлбөр нэвтрүүлэх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 1 баг болгон зарласан байна.

Үдийн хоолны материал нийлүүлэх 3 багц, Софтвишн ХХК шалгарч тендерт үдийн хоолны материал 185,252.5 мянган төгрөгийн бараа материал нийлүүлэхээр 2024 оны 04 сарын 01, 2024 оны 05 сарын 07-ны өдрөөс, Гэгээн их ХХК 1 багцад шалгарч 64,185.0 мянган төгрөгийн бараа материал нийлүүлэх гэрээг 2024 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хугацаанд хүртэл байгуулан ажилласан байна.

Ерөнхий боловсролын сургуульд цахим системд суурилсан англи хэлний хөтөлбөр нэвтрүүлэх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт АЙ И ДИ СИ ХХК шалгарч 43,652.9 мянган төгрөгийн ажил үйлчилгээ нийлүүлэхээр 2024 оны 05 сарын 07-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд гэрээ байгуулсан байна.

Худалдан авах гэрээний үнийн дүнг мөрдөн ажиллаж гэрээг дүгнэн ажилласан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Номгон аудит” ХХК-ийн аудитор О.Мандах гүйцэтгэж, 6591.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоон байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|----------|------------------------|---------|---------|---------|------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 3 | 6,591.7 | 3 | 6,591.7 | 100 |
| Нийт дүн | 3 | 6,591.7 | 3 | 6,591.7 | 100 |

Эх сурвалж: төлбөрийг 2024 оны 03.26, 2024,3,12 –ны төлбөрийн баримтууд

Аудитаар өгсөн төлбөрийн актын хэрэгжилтийг тус байгууллагаас 2024.05.09-ны өдөр 118 дугаар албан бичгээр ирүүлж бүрэн биелүүлж ажиллажээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын урамшууллыг олгохдоо “Өөрчлөлтгүй” гэж дүгнэгдсэн боловч төлбөрийг акт тогтоосон байхад нягтлан бодогч үндсэн цалингийн 3 сартай тэнцэх хэмжээний урамшуулал олгох тушаал гарган олгосон байна. Иймд дараагийн аудитаар дээрх урамшууллыг хавтгайруулан олгосон эсэх асуудлыг авч үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,547.2 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрсэнд 2,003.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,544.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өглөө.

5.1 Албан шаардлага

1. Боловсролын байгууллагын онцлогоос шалтгаалж 2024 оны 6 дугаар сард олгосон ээлжийн амралтын мөнгийг нийгмийн даатгалын мэдээнд 6-8 саруудад мэдээлэхдээ 4 ажилтны цалингаас суутган тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 1,347.9 мянга, ХХАОТ-ын өглөг 655.2 мянган төгрөгийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй, нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээ, татварын мэдээнд тайлагнаагүй байна.

Дээрх зөрчил нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.”Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө” гэсэн заалтыг зөрчиж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5.”дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна., “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ХХАОТ-ын тайлан, Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд 4 ажилтны цалинг нөхөн мэдээлж холбогдох өглөгийг барагдуулах албан шаардлага өгөв.

2. Боловсрол Шинжлэх ухааны яамны 2024.06.24-ны өдрийн 2/2772 дугаар албан бичгийг үндэслэн аймгийн Боловсролын газрын даргын 2024.07.09-ний өдрийн “Урамшуулал олгох тухай” Б/42 дугаар тушаалаар төсвийн шууд захирагчид балансын урамшуулал нэг сарын цалинтай тэнцэх 1,544.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6,4,1 төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах мөн 16,5,5 - батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн шууд захирагч нарт балансын урамшуулал олгодог байдлыг таслан зогсоох зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | /мянган төгрөгөөр/ | | | | | |
|--|-------------|---------|--------------------|--|-----------------|---------|---------|-----|
| | | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлантай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн өглөгийг 1374,9 мянган төгрөгөөр, ХХОАТ-ын өглөгийг 655.2 мянган төгрөгөөр дутуу тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.дэх заалттай нийцэхгүй байна. | 1 | 2,003.2 | | | 1 | 2,003.2 | | |
| Төсвийн шууд захирагчид балансын урамшуулал нэг сарын цалинтай тэнцэх урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалттай нийцэхгүй байна. | 1 | 1,544.0 | | | 1 | 1,544.0 | | |
| Нийт дүн | 2 | 3,547.2 | | | 2 | 3547.2 | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo---